



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар Д/606

Хэрлэн сум

Мал, тэжээвэр амьтдын
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр “Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг 2023 оны 12 дугаар сарын 7-оос 2023 оны 12 дугаар сарын 17-ны хооронд явуулсугай.

2. 2023 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Орлогч дарга:	Г.Сэдэдмаа	Аймгийн Статистикийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Ц.Батхишиг	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүдэд:	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	А.Гантөмөр	Татварын хэлтсийн дарга
	Г.Мөнх-эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга

2.

Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга, Дэд хурандаа
Б.Хэрлэнчимэг	Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга

3.Жилийн эцсийн мал тооллогын хяналтын зардалд зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

4.Жилийн эцсийн мал тооллогын холбогдох зардлыг шийдвэрлэхийг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Мал тооллогын хяналтанд зарцуулах 4,660,800 (дөрвөн сая зургаан зуун жаран мянга найман зуун) төгрөгийг Аймгийн Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

6.Жилийн эцсийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж, сумдын ажлын хэсэгт мэргэшил, арга зүйн зөвлөмж өгч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дугаар сарын 29-ны ... дугаар захирамжийн хавсралт

Хэнтий аймгийн 2023 оны жилийн эцсийн мал тооллогын хяналтын ажлаар комиссын гишүүдийн хөдөө орон нутагт ажиллах томилолт, унааны төсөв

2023.11.27

Он	Комиссын гишүүдийн тоо	Ажиллах сумдын тоо	Баг бүрт 2 айлаар орно айл хооронд 50 км	Унааны мөнгө /100км*20л/	Томилолтын зардал /хоногийн 64000 нэг суманд 2 хоног /	Нийт зардал
2022	2	4	32	806400	1024000	3203200
	2	3	24	604800	768000	
	Нийт дүн	7	56	1411200	1792000	
2023	4	8	32	1612800	2048000	4660800
	9	10	45	1000000	0	
	Нийт дүн	8	77	2612800	2048000	